

НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Улаанбаатар такси каб ХХК-ийн 2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: НТАГ-2025/057/НА-СТА-ОНӨҮГ

<p>Цахим хуудас: www.audit.mn</p> <p>Улаанбаатар хот</p> <p>2025 он</p>	<p>Нийслэл дэх Төрийн аудитын газрын дэд дарга: Ч.Болд Утас: 70007734 Цахим хаяг: boldch@audit.gov.mn</p> <p>Хэлтсийн дарга: Х.Түвшинбаяр Утас: 315558 Цахим хаяг: tuvshinbayarh@audit.gov.mn</p> <p>Аудитын менежер: Д.Отгонбаяр Утас: 261628 Цахим хаяг: otgonbayard@audit.gov.mn</p> <p>Аудитыг гэрээгээр гүйцэтгэгч Ниямазон аудит ХХК, захирал З.Цээнээ Утас: 99135906 Цахим хаяг: audit@nmz.mn</p>
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
НИЙСЛЭЛ ДЭХ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,
Утас: 7000 7734, Факс: (976-11) 32 01 54
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.audit.mn

2025. 03. 14 № 01/292
танай _____-ны № _____-т

УЛААНБААТАР ТАКСИ КАБ
ХХК-ИЙН ХУВЬЦАА
ЭЗЭМШИГЧДИЙН ЭРХИЙГ
ХЭРЭГЖҮҮЛЭГЧ УЛААНБААТАР
ХОТЫН ХӨГЖЛИЙН
КОРПОРАЦИ ХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ
Ж.САНДАГСҮРЭН ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Улаанбаатар такси каб ХХК-ийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудыг бүх материаллаг талаар нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Компани 2018 онд байгуулагдсанаасаа хойш дүрэмд заасан үйл ажиллагааг эрхлээгүй, ашиг олоогүй, нийт хөрөнгө 18,552.1 мянган төгрөг, нийт өр төлбөр 43,253.0 мянган төгрөг болж өөрийн хөрөнгөгүй болсон. Байгууллагын нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчим алдагдсан байна.

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ.

Аудитын гол асуудал

Улаанбаатар такси каб ХХК-ийн гүйцэтгэх захирлаар ажиллаж байсан Г.Ариунболдын нэхэмжлэлтэй шүүхийн маргаан 2024 онд үргэлжилж, анхан шатны шүүхээс нэхэмжлэлийг бүхэлд нь хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн боловч шүүхийн шийдвэрийг хариуцагч гардан аваагүй, шүүхийн маргаан эцэслэн шийдвэрлэгдээгүй байна.

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Компани нь тайлант онд үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулаагүй, биелэлтийн тайлангүй байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



М.ЭРДЭНЭЖАРГАЛ

Нийслэлийн Улаанбаатар такси каб ХХК-ийн 2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын хураангуй тайлан

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Мөрийн дугаар	Үзүүлэлт	/төгрөгөөр/	
		2023 оны 12 сарын 31	2024 оны 12 сарын 31
	Б	1	2
1	ХӨРӨНГӨ		
1.1.1	Мөнгөн хөрөнгө	26,787.96	14,787.96
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	4,153,000.00	4,153,000.00
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	4,179,787.96	4,167,787.96
1.2	Эргэлтийн бус хөрөнгө		
1.2.1	Үндсэн хөрөнгө	18,330,850.81	14,384,350.81
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	18,330,850.81	14,384,350.81
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	22,510,638.77	18,552,138.77
2.1.1.1	Дансны өглөг	6,153,000.00	8,153,000.00
2.1.1.8	Бусад богино хугацаат өр төлбөр	37,100,000.00	37,100,000.00
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	43,253,000.00	45,253,000.00
2.2	Өр төлбөрийн нийт дүн	43,253,000.00	45,253,000.00
2.3.1	Өмч: -төрийн	100,000.00	100,000.00
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг	29,990,000.00	29,990,000.00
2.3.9	Хуримтлагдсан ашиг	(50,832,361.23)	(56,790,861.23)
2.3.9.1	Тайлангийн үеийн ашиг	(41,058,500.00)	(5,958,500.00)
2.3.9.2	Өмнөх үеийн ашиг	(9,773,861.23)	(50,832,361.23)
2.3.11	Эздийн өмчийн дүн	(20,742,361.23)	(26,700,861.23)
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	22,510,638.77	18,552,138.77

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

Мөрийн дугаар	Үзүүлэлт	/төгрөгөөр/	
		2023 оны 12 сарын 31	2024 оны 12 сарын 31
1	Борлуулалтын орлого (цэвэр)		
2	Борлуулалтын өртөг		
3	Нийт ашиг(алдагдал)	-	-
10	Ерөнхий ба удирдлагын зардал	5,958,500.00	5,958,500.00
12	Бусад зардал	-	-
18	Татвар төлөхийн өмнөх ашиг(алдагдал)	(5,958,500.00)	(5,958,500.00)
19	Орлогын татварын зардал	-	-
20	Татварын дараах ашиг (алдагдал)	(5,958,500.00)	(5,958,500.00)
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	(5,958,500.00)	(5,958,500.00)
24	Орлогын нийт дүн	(5,958,500.00)	(5,958,500.00)
25	Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)		

Нийслэлийн Улаанбаатар такси каб ХХК-ийн 2024 оны санхүүгийн тайланд
хийсэн аудитын хураангуй тайлан

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

	Үзүүлэлт	Өмч	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
01	2022 оны 12 сарын 31	100,000.00	29,990,000.00	(9,773,861.23)	20,316,138.77
02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-	-
03	Залруулсан үлдэгдэл	100,000.00	29,990,000.00	(9,773,861.23)	20,316,138.77
04	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	(41,058,500.00)	(41,058,500.00)
09	2023 оны 12 сарын 31	100,000.00	29,990,000.00	(50,832,361.23)	(20,742,361.23)
11	Залруулсан үлдэгдэл	100,000.00	29,990,000.00	(50,832,361.23)	(20,742,361.23)
12	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)			(5,958,500.00)	(5,958,500.00)
17	2024 оны 12 сарын 31	100,000.00	29,990,000.00	(56,790,861.23)	(26,700,861.23)

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТ	2023 оны 12 дугаар сарын 31	2024 оны 12 дугаар сарын 31
Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
Мөнгөн орлогын дүн (+)		
Бусад мөнгөн зарлага	12,000.00	12,000.00
Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(12,000.00)	(12,000.00)
Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	(12,000.00)	(12,000.00)
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	38,787.96	26,787.96
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	26,787.96	14,787.96

**Нийслэлийн Улаанбаатар такси каб ХХК-ийн 2024 оны санхүүгийн тайланд
хийсэн аудитын хураангуй тайлан**

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар компани үйл ажиллагаа явуулаагүй, шүүхийн маргаантай байгаатай холбоотой зөрчил¹ илэрч 1 зөвлөмж өгсөн.

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаа лтны тоо	Тоо	Дүн
УБТК ХХК үйл ажиллагаа эрхлээгүй, тасралтгүй байдлын зарчим алдагдсан, өр төлбөртэй	1	-					1	-				
Дүн	1	-					1	-				

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.